# Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын систем

Даатгалын ажилтан эрхийн гарын авлага

# Гэрээ байгуулах - Даатгалын бүтээгдэхүүн хуудас




Үндсэн ажилтан системд нэвтэрч орсны дараагаар хамгийн эхэнд дуудагдах хуудас нь даатгалын тооцоолуур байна.

# Гэрээ байгуулах – Даатгуулагчийн мэдээлэл хуудас




Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний төрөл нь

1. Хувь хүний
2. Хуулийн этгээд
3. Мэргэшсэн С,Д
4. Дамжин өнгөрөх гэсэн нийт 4 төрөлтэй байх ба даатгуулагчийн мэдээлэл хуудсанд гэрээний төрлийг сонгодог байна.

# Гэрээ байгуулах – Даатгуулагчийн мэдээлэл хуудас




Гэрээний төрлийг сонгож
**Хувь хүний, Хуулийн этгээд** гэсэн үед доорх асуулгын асууна

- Гаальтай машин эсэх
- Гадаадын иргэн эсэх
- Нэр шилжиж байгаа эсэх гэсэн toggle  switch ийг сонгон даатгалыг хийнэ.

1. Гаальтай машин

Гаальтай машин гэсэн toggle switch нь тухайн машин улсын дугаар аваагүй үед буюу арлын дугаараар тээврийн хэрэгслийн даатгах үед ашиглана.

2. Гадаадын иргэн эсэх

Гадаадын иргэн эсэх switch toggle г сонгосноор гадаадын иргэний РД аар даатгал хийх боломжтой байна.

3. Нэр шилжиж байгаа эсэх

Өмчлөгч өөрчлөгдөхөөс өмнө даатгуулах шаардлагатай үед тухайн switch toggle г сонгон даатгал хийнэ.

# Гэрээ байгуулах – Даатгуулагчийн мэдээлэл хуудас




**Алхам 1**. Даатгалын гэрээ нь Хувь хүн, Хуулийн этгээд, Мэргэшсэн, Дамжин өнгөр гэсэн 4 төрөлтэй байх ба эдгээрээс даатгал хийх төрлөө сонгоно.

**Алхам 2**. Дамжин өнгөрөх төрлийн хувьд дотроо хувь хүн, хуулийн этгээд гэсэн 2 дэд төрөлд хуваагдах тул Даатгуулагчийн төрөл талбараас сонголт хийнэ.

**Алхам 3**. Эдгээр талбаруудын утгыг гараас оруулна. Даатгуулагчийн регистрийн дугаар болон Тээврийн хэрэгслийн улсын дугаараар ХУР-аас мэдээлэл татаж байгаа тул сайн шалгана уу.

**Алхам 4**. Жолоо хамт барих жолоочгүй бол тус товчийг идэвхижүүлэх шаардлагагүй шууд үргэлжлүүлэх товч дарахад дараагийн хуудас руу шилжинэ.

# Гэрээ байгуулах – Даатгуулагчийн мэдээлэл хуудас




**Алхам 5**. Жолоочийн тоо хязгаарлах toggle-ийг идэвхижүүлсэн тохиолдолд Хамт жолоо барих жолоочийн мэдээллийг оруулах талбар гарч ирнэ. Жолооч шинээр нэмэх болон арилгах үйлдэл хийх боломжтой.

**Алхам 6.** Үргэлжлүүлэх товч дарахад даатгуулагч нь МУ-ын иргэн бол мэдээлэл ХУР-аас татагдах ба мэдээлэл хуваалцахыг баталгаажуулах код даатгуулагч руу илгээгдэнэ.

**Алхам 7**. Утасны дугаар болон имэйл хаягын ард байрлах toggle-уудын аль нэгийг идэвхижүүлснээр баталгаажуулах кодыг сонгосон сувгаар авах боломжтой.

**Алхам 8.** Кодыг доорх талбаруудад бөглөж баталгаажуулах товчийг дарснаар цааш үргэлжлүүлэх товчийг дарна.




!!! Дамжин өнгөрөх жолоочийн даатгалыг хийхэд баталгаажуулалт шаардахгүй.

# Гэрээ байгуулах – Тээврийн хэрэгслийн мэдээлэл хуудас




**Алхам 1.** Даатгуулагч нь Монгол Улсын иргэн бол талбарууд автоматаар нөхөгдөнө. МУ-д бүртгэлгүй буюу дамжин өнгөрч буй этгээдийн болон хамтран жолоочийн хувьд мэдээллийг гараас бөглөж, хадгалах товч дарна.

# Гэрээ байгуулах – Тээврийн хэрэгслийн мэдээлэл хуудас




**Алхам 2.** Даатгалын компанийг сонгож тооцоолол хийх товч дарснаар хураамжийн тооцооллын хуудас руу шилжинэ.

# Гэрээ байгуулах – Хураамж тооцоолох хуудас




**Алхам 1.** Энэхүү хуудсанд даатгалын суурь хураамж, итгэлцүүрийн утга болон нийт хураамжийн төлбөрийн мэдээлэл харагдана. Гэрээ хийх товчийг дарахад дараагийн хуудас руу шилжинэ.

# Гэрээ байгуулах – Хураамж тооцоолох хуудас




Энэхүү хуудсанд даатгалын гэрээний мэдээлэл автоматаар бөглөгдөж, pdf хэлбэрээр харагдана.

Гэрээний PDF файлыг татах, хэвлэх боломжтой.

ТӨЛБӨР ТӨЛӨХ товчийг дарснаар гэрээний төлбөрийн нэхэмжлэлийн хуудас руу шижинэ.

# Гэрээний жагсаалт

Таб солин гэрээний төлөвөөр гэрээний жагсаалтыг филтердэж харна.




Гэрээний жагсаалтыг эксел файлаар татах боломжтой.

Админ гэрээний төлөвөөс хамаарч дараах үйлдлүүдийг хийх боломжтой.

- Гэрээ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ төлөвтэй бол БАТАЛГААЖУУЛАХ товчийг дарснаар гэрээг цааш үргэлжлүүлэх боломжтой.

- Гэрээ БАТАЛГААЖСАН төлөвтэй бол PDF гэрээг харах, гэрээг цуцлах, хүчингүй болгох үйлдэл хийгдэнэ.

Гэрээний жагсаалтаас тухайн гэрээтэй холбоотой дараах мэдээллээр хайлт хийх боломжтой.

- Даатгуулагчийн төрөл
- Гэрээний эхлэх болон дуусах огноо
- Түлхүүр үг

# Гэрээ дуудах




Гэрээ дуудах цэсээр тухайн компани дээр үүсгэсэн нийт гэрээг дуудаж харах боломжтой байна. Гэрээ дуудах хуудсын жагсаалт хэсэг хоосон харагдах ба

1. РД
2. Гэрээний дугаар эсвэл улсын дугаараар хайлт хийн гэрээг дуудах боломжтой байна.







Гэрээг дуудсанаар тухайн гэрээний дэлгэрэнгүй PDF файлыг харах, ТХ улсын дугаарыг солих болон тухайн гэрээг цуцлах хүсэлт илгээх боломжтой байна.

# Төлбөр тооцоо




Гүйлгээний жагсаалтаас тухайн гэрээтэй холбоотой хайлт хийх.

- Даатгуулагчийн төрөл
- Түлхүүр үгээр

Гүйлгээний жагсаалтыг эксел файлаар татах

Ажилтан тухайн гэрээтэй холбоотой гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг энэхүү хуудаснаас харна.

# Багц даатгал

Хуулийн этгээдийн даатгалын гэрээний төрөл дээр БАГЦ ДААТГАЛ үүсгэх боломжтой ба энэ нь тухайн хуулийн этгээд дээр үүсэх олон тооны даатгалын гэрээний хураамжийг нийтэд нь төлөх боломжтой юм.

*Багц даатгал үүсгэхийн тулд:*




**Алхам1.** Хуулийн этгээд дээр багц үүсгэн дараа төлөх бол хуулийн этгээдийн төрлийг гэрээ байгуулах алхмын дагуу талбарын мэдээллүүдийг бөглөн БАГЦ ГЭРЭЭНД ХАДГАЛАХ товчийг дарж багц гэрээ үүсгэнэ.




**Алхам2.** Багц гэрээнд хадгалах товч дарснаар "Багцын даатгалын жагсаалт" хуудас руу шилжинэ. Тус хуудсанд багцаар төлөх хуулийн этгээдүүдийн жагсаалт харагдана.
Жагсаалтаас түлхүүр үг болон огноогоор хайлт хийх боломжтой байна. Хуулийн этгээдийн tooltip menu гээс дэлгэрэнгүй товчийг дарахад үүсгэсэн тээврийн хэрэгслийн жагсаалт харагдана.

# Багц даатгал




**Алхам3.** Багцын жагсаалт хуудсанд хуулийн этгээд дээр үүссэн нийт тээврийн хэрэгслийн тоо нийт хураамжийн дүн болон тээврийн хэрэгслийн жагсаалт харагдана. Багцын жагсаалтаас тээврийн хэрэгслийг устгах боломжтой байна. ТӨЛБӨР ТӨЛӨХ товчийг дарснаар багцын төлбөрийг нийтэд төлнө.




**Алхам4.** Төлбөр төлөх товч дээр дарахад төлбөр төлөх POPUP хуудас харагдана.Төлбөрийг qpay болон шилжүүлгээр төлөх боломжтой байна.